

## ТАНИЛЦУУЛГА

**2020.07.28**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль 2005 онд батлагдсантай холбоотой, түүнийг дагалдан худалдан авах ажиллагаатай холбоотой журам, заавар, аргачлал, жишиг баримт бичгүүд батлагдсан.

Өнөөдрийн байдлаар дараах 13 тендерийн жишиг баримт бичиг батлагдан улсын хэмжээнд бүх шатны захиалагч байгууллага худалдан авах ажиллагаа зохион байгуулахдаа мөрдөж ажиллаж байна. Үүнд:

№	Жишиг баримт бичгийн нэр	Анх баталсан огноо	Нэмэлт, өөрчлөлт орсон байдал	Хүчин төгөлдөр огноо
1	Үнийн санал авах ЖББ-Зөвлөхөөс бусад	2002 он №382/346	2	2009 он №158
2	Бараа нийлүүлэх ТЖББ	ЗГ-ын тогтоол 2000 он №101	4	2012 оны №81 1 дүгээр хавсралт
3	Ажил гүйцэтгэх ТЖББ	ЗГ-ын тогтоол 2000 он №101	4	2012 оны №81 2 дугаар хавсралт
4	Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах ТЖББ	2001 он №143	3	2012 он №194 1 дүгээр хавсралт
5	Мэдээллийн систем нийлүүлж, суурилуулах ТЖББ	2001 он №143	3	2013 он №243 2 дугаар хавсралт
6	Сурах бичиг худалдан авах ТЖББ	2001 он №143	3	2013 он №243 1 дүгээр хавсралт
7	Зөвлөхөөс бусад үйлчилгээний ТЖББ		2007 он №176	
8	Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй ТЖББ		2008 он №362	
9	Урьдчилсан сонголт явуулах ЖББ		2007 он №184	
10	Зөвлөх үйлчилгээний ТЖББ		2012 он №194 2 дугаар хавсралт	
11	Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны ТЖББ		2013 он №39 2 дугаар хавсралт	
12	Үнийн санал авах ЖББ-Бараа		2013 он №125 1 дүгээр хавсралт	
13	Үнийн санал авах ЖББ-Ажил		2013 он №125 2 дугаар хавсралт	

Хууль батлагдсантай холбоотой анх 2000 онд “Бараа нийлүүлэх тендерийн жишиг баримт бичиг” болон “Ажил гүйцэтгэх тендерийн жишиг баримт бичиг” батлагдаж, түүнээс хойш 4 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна.

Улсын Их Хурал 2019 онд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан, мөн цахим худалдан авах ажиллагааны тогтолцоо руу шилжсэнтэй холбогдуулан тендерийн жишиг баримт бичгийг шинэчлэн батлах ажлыг хийж байна.

“Бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичиг”-ийн шинэчилсэн төсөлд дараах өөрчлөлтүүдийг тусгалаа. Үүнд:

- Энэхүү тендерийн жишиг баримт бичгийг тендер шалгаруулалтын журам, аргаас үл хамааран харьцуулалтын босго үнээс давсан тендер шалгаруулалт зохион байгуулахад ашиглана;

- Тендер шалгаруулалтын журам, арга, төсөвт өртгөөс үл хамааран тендер шалгаруулалтыг бүх шатны захиалагч байгууллага цахим системээр зохион байгуулна;
- Захиалагч тендерт оролцогчид тавих шалгуур болон бүрдүүлэх материалын талаар тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэд тусгахдаа тендерийн баримт бичгийн оролцогчид өгөх зааварчилгаатай уялдуулан нэг шалгуур үзүүлэлтийг хэд хэдэн газар давхардуулж заах, материалыг хэд хэдэн хувилбараар шаарддаг байсныг хуулийн 14-16 дугаар зүйлтэй уялдуулан давхардлыг арилган нэг дор тусгах боломжтой болно.
- Тендер шалгаруулалтыг гэрээний эрх зүйн харилцаанаас тусад нь салгаж гэрээнд зайлшгүй дагаж мөрдөх заалтыг тендер шалгаруулалтын зааварчилгаа болон тендерийн өгөгдлийн хүснэгтэд тусгаж өгсөн. Хуулийн 40 дүгээр зүйлийн 40.5 дахь хэсэгт заасны дагуу худалдан авах ажиллагаанд мөрдөх гэрээний стандарт нөхцөлийг тусад нь батална.

Дээрх тендерийн жишиг баримт бичиг өөрчлөгдсөнтэй холбоотой гэрээний загварыг шинэчлэлээ. Бараа худалдах, худалдан авах гэрээний зүйл, заалтыг агуулгаар өөрчлөгдөх шаардлаггүй байсан тул гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд найруулга, нэр томъёоны шинжтэй өөрчлөлтүүдийг хийсэн болно. Мөн түүнчлэн алдангийн зохицуулалтыг Иргэний хуультай нийцүүлэн боловсрууллаа.

Цаашид бусад тендерийн жишиг баримт бичгүүдийг хэрэглээ, стандарт зүйл заалттай нийцүүлэн ижил төстэй байдлаар нь нэгтгэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг тусган шинэчлэх ажил үе шаттайгаар хийгдэх юм.

--o0o--